



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/06/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: О.Баярмаа Утас: 261628 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: nyamsurenn@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

2023.03.24 № 01/680
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зам, тээврийн сайдын 2015 оны 130 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалаар Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах тухай журмын дагуу төлбөр хураах үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-т шилжүүлсэн. Төлбөр хураах 30 цэгээр дамжуулан тайлант онд 13,545,476.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь төлөвлөснөөс 11,454,707.3 мянган төгрөгийг дутуу, өмнөх оноос 35.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тус сангийн үйл ажиллагааны урсгал зардлыг Зам, тээврийн хөгжлийн төвөөр дамжуулан зарцуулдаг, тайлант оноос эхлэн тусдаа аудитын дүгнэлт гаргаж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд улсын төсвөөс 42,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 25,000,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 67,100,000.0 мянган төгрөгийг урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 42,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 13,545,476.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 50,710,557.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 4,910,949.5 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, улсын төсөвт 17,096.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 23,988.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,061,987.1	4,739,515.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	226,569.8	281,738.5
33	АВЛАГА	-	9,739.0
34	УРЬДЧИЛГАА	775,156.8	875,156.8
35	БАРАА МАТЕРИАЛ	60,260.5	99,315.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	3,473,565.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,448,722.2	6,204,884.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,448,722.2	6,204,884.7
39200	Биет хөрөнгө	6,444,762.2	6,165,315.8
39300	Биет бус хөрөнгө	3,960.0	39,568.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,510,709.3	10,944,400.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	520,936.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	520,936.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,510,709.3	10,423,464.0
51	Засгийн газрын хувь оролцоо	7,510,709.3	10,423,464.0
51200	Хуримтлагдсан үр дүн	7,126,158.0	10,038,912.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,551.4	384,551.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,510,709.3	10,944,400.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	41,407,339.5	55,676,675.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,407,339.5	13,576,675.4
120	Нийтлэг татварын бус орлого	11,407,339.5	13,576,675.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,000,000.0	42,100,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,000,000.0	42,100,000.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,893,116.3	5,006,895.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,893,116.3	5,006,895.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,117,820.5	4,932,973.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,218,429.5	3,014,963.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	297,293.8	379,727.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,629.7	184,413.8
2104	Хангамж, бараа материалын зардал	100,566.3	179,631.1
2105	Нормативт зардал	11,935.3	135,709.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,825.5	204,794.3
2107	Томилолт, зочны зардал	9,456.3	22,602.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,217.3	446,473.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,466.8	364,657.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	775,295.9	73,922.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,464.9	56,826.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	764,831.0	17,096.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	37,514,223.2	50,669,779.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	36,002,368.2	47,757,025.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,511,925.0	2,912,754.6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	40,032,346.4	55,676,675.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,032,346.4	13,576,675.4
120	Нийтлэг татварын бус орлого	10,032,346.4	13,576,675.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,000,000.0	42,100,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,000,000.0	42,100,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,765,331.0	4,841,649.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,765,331.0	4,841,649.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,000,500.0	4,824,553.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,000,500.0	4,824,553.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	764,831.0	17,096.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	764,831.0	17,096.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,267,015.4	50,835,025.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,267,015.4	50,779,857.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,267,015.4	50,779,857.2
2200	Дотоод эх үүсвэрээр	36,267,015.4	50,779,857.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	36,267,015.4	50,779,857.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	55,168.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	226,569.8	226,569.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,569.8	281,738.5

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	384,551.4	5,614,233.0	5,998,784.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	384,551.4	5,614,233.0	5,998,784.4
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,511,925.0	1,511,925.0
11	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	384,551.4	7,126,158.0	7,510,709.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	384,551.4	7,126,158.0	7,510,709.3
19	Тайлант үеийн үр дүн	-	-	2,912,754.6	2,912,754.6
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	384,551.4	10,038,912.6	10,423,464.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,100,000,000.00	55,621,506,706.02	(11,478,493,293.98)	82.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000,000.00	4,910,949,465.02	(89,050,534.98)	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000,000.00	4,910,949,465.02	(89,050,534.98)	98.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000,000.00	4,910,949,465.02	(89,050,534.98)	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000,000.00	4,910,949,465.02	(89,050,534.98)	98.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,100,000,000.00	50,710,557,241.00	(11,389,442,759.00)	81.7
223001	Бусад хөрөнгө	62,100,000,000.00	50,710,557,241.00	(11,389,442,759.00)	81.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,100,000,000.00	55,645,292,706.46	(11,454,707,293.54)	82.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,100,000,000.00	42,100,000,000.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	42,100,000,000.00	42,100,000,000.00	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000,000.00	13,545,292,706.46	(11,454,707,293.54)	54.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000,000.00	13,545,292,706.46	(11,454,707,293.54)	54.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,600.00	19,600.00	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,988,940.44	23,988,940.44	100.0
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	285	262	23	91.9
	Удирдах ажилтан	9	9	-	100.0
	Үйлчлэх ажилтан	276	253	23	91.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	226,550,248.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	226,550,248.93

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 80,372.5 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой 2 алдаа илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа.

Аудитаар нийт 365,666.1 мянган төгрөгийн 11 зөрчил илэрснээс, 600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 35,700.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 329,366.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 365,666.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 671,000.0 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгаагүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөр авах цэг	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 40.6 сая төгрөгийн хөрөнгийг Бараа материалын сэлбэг хэрэгсэл дансанд бүртгэсэн байна.	1	40,620.0			1	40,620.0	1	40,620.0
Улсын авто замын сан	Үндсэн хөрөнгийн шинж чанартай барааг материалыг хөрөнгийн дансанд бүртгэсэн.	1	39,752.5			1	39,752.5	1	39,752.5
Дүн		2	80,372.5	-	-	2	80,372.5	2	80,372.5

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөр хураах цэг	Зам Тээврийн хөгжлийн төвийн захирлын 2022 оны 10 дугаар сарын А/126 дугаар тушаалаар Авто замын салбар үүсэж хөгжсөний түүхт 93 жилийн ойг тохиолдуулан нэр бүхий ажилтнуудад 600.0 мянган төгрөгийн шагнал олгосон байна.	1	600.0	1	600.0				
Төлбөр хураах цэг	Тайлант хугацаанд худалдан авсан 16,200.0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг буруу тооцож, тайлант хугацааны элэгдлийн зардлыг илүү бүртгэсэн байна	1	-					1	-
Харьяа байгууллагын нийт дүн		2	600.0	1	600.0			1	-
Улсын авто замын сан	Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын санхүүжилтийг тусгай зам буюу ЗТХС-ын 2021 оны А/147 дугаар тушаалаар тусгай замын жагсаалтад оруулсан Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах Их Харгуйн Зам ХХК барьж, 2020 оны 1 дүгээр сард ашиглалтад өгсөн Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох 17.5 км хүнд даацын хатуу хучилттай Т08 дугаартай замд 35,700.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	35,700.0			1	35,700.0		
Улсын авто замын сан	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн А0502 дугаартай 330.2 км замаас улсын комисс хүлээж аваагүй 50 км замд 110,600.0 мянган төгрөгийн засвар, арчлалтын санхүүжилт олгохоор төлөвлөгөөнд тусгасны дагуу гүйцэтгэлийг бүрэн олгосон байна.	1	110,600.0					1	110,600.0

Улсын авто замын сан	Тус сангийн төсвөөс авто замын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зардалд нийт төсвийн 20.4 хувийг зарцуулсан нь төсвийг төлөвлөх, хуваарилах зарчимтай нийцэхгүй, 10.4 хувийг үйл ажиллагааны ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.	1	-					1	-
Улсын авто замын сан	Авто зам, замын байгууламжид үүссэн гэнэтийн эвдрэл, саатлыг арилгах, сэргээн засварлах буюу "Онцгой" ажлын төлөвлөгөө 6,001,220.0 мянган төгрөгөөс 218,766.1 мянган төгрөгийг авто замын ээлжит болон урсгал засварт ангилал зөрүүлэн зарцуулсан байна.	1	218,766.1					1	218,766.1
Улсын авто замын сан	Азийн хөгжлийн банкны МОН-3129 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн хүрээнд нийлүүлсэн 4 төрлийн тусгай зориулалтын авто замын засвар, арчлалтын техникийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, тушаал шийдвэрт хөрөнгийн өртөг, зээлийн хүү, ханшийн алдагдлын талаарх мэдээлэл тодорхойгүй, ЗТХЯ-ны 2022.02.14-ний өдрийн 05/601 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.	1	-			1	-		
Улсын авто замын сан	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар түлхүүр гардуулах нөхцөлтэй "Төлбөр авах цэг барих" ажлыг хугацаандаа гүйцэтгээгүйгээс төлбөр хураах цэгийн орлого 9-24 сараар тасалдсан байна. Мөн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэгч тал нь барилгын чанар, ажлын технологийн алдаанаас үүдэн гарсан эвдрэл, гэмтлийг өөрийн хөрөнгөөр 3 жил засварлахаар тогтоох ёстой байсан боловч ашиглалтын хугацааг 1 жилээр тооцсон зөрчил илэрсэн.	1	-					1	-
Улсын авто замын сан	Улсын хэмжээнд төлбөр авах нийт 34 цэг бүртгэлтэй бөгөөд тайлант онд 30 цэгээр дамжуулан 13,576.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн хэдий ч үйл ажиллагаа бүрэн цахимжаагүй, дотоод хяналт хангалтгүй,	1	-					1	-
Улсын авто замын сан	Олон улс, улсын чанартай авто зам засаж, арчлах төсвөөс орон нутгийн зориулалттай гүүр хамгаалалтын ажилд 248,489.3 мянган төгрөгийг олгосон,	1	-					1	-
Улсын авто замын сан	Улсын болон олон улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын 2022 оны төлөвлөгөөнд 62,100,000.0 мянган төгрөгийн ажлыг хийж, гүйцэтгүүлэхээр 20 ТӨХК, 12 ХХК-ийг сонгон шалгаруулж, санхүүжилт олгосон боловч 33,765,276.9 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байгаа нь харилцагч байгууллагууд татвар ногдуулах орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг тодорхойлохдоо бодит бус үнийн дүнг ашиглах, татвараас зайлсхийх боломж олгож, мөн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгасан байна.	1	-					1	-
НИЙТ		11	365,666.1	1	600.0	2	35,700.0	8	329,366.1

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал							
Төлбөр авах цэг	Шилэн дансны цахим хуудсанд 29,197.4 сая төгрөгийн 671 мэдээллийг ил тод байршуулахаас 5 сая төгрөгөөс дээш 110.4 сая төгрөгийн 8 орлогын гүйлгээ, 697.4 сая төгрөгийн 14 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	1	807,709.3			1	807,709.3
Улсын авто замын сан	1.2019 онд шинэчлэн батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ыг шинэчлэн батлаагүй, 2.Авто замын бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах, авто замын сангийн орлого, хөрөнгийн зарцуулалтад тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий зам хэрэглэгчид болон иргэдийн төлөөллөөс бүрдсэн "Авто замын зөвлөл"-ийг байгуулж, 3.Авто замын зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, сонгон шалгаруулах журам, шалгуур үзүүлэлтийг баталсан эрх зүйн баримт боловсруулж, батлаагүйгээс ТЕЗ-ийн зүгээс тавих дотоод хяналт сул байна.	1	-			1	-
Улсын авто замын сан	"Авто замын бүртгэл, мэдээллийн сан" дахь хуульд заасан заавал тусгавал зохих мэдээлэл дутуу байна. Тухайлбал: тусгай зориулалтын зам, асфальтан замын элэгдэл хорогдол, авто зам, замын байгууламжид хийсэн засварын мэдээлэл, авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл ослын талаарх мэдээллүүд огт бүртгэлгүй, зарим асфальтан замын өртгийг бүртгэлжүүлээгүй байна.	1	-	1	-		
Улсын авто замын сан	1.Төрийн захиргаа удирдлагын газраас Зам тээврийн хөгжлийн яамны харьяа ТӨХК-ийн ТУЗ-д гишүүнчлэл хэрэгжүүлж байгаа албан хаагчдын мэдээлэл гаргуулан авахад зөрүүтэй буруу мэдээлэл өгсөн 2.ТӨХК-ийн төрийг төлөөлөх этгээд буюу Зам тээврийн хөгжлийн яамны зарим албан хаагч 6 хүртэлх компанийн ТУЗ-д ажиллаж, давхар цалин авч байгаа асуудлыг ил тод нээлттэй мэдээлээгүй байна.	1	-			1	-
Улсын авто замын сан	ЗТХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Улсын авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд сүүлийн 5 жил хяналт шалгалт хийгээгүй нь зам арчлалын компаниудтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт биелэхгүй байх үндэслэл болж байна.	1	-	1	-		
	Дүн	5	807,709.3	2	-	3	807,709.3